МЭДЭЭ · 2022 оны 9-р сарын 29

"ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ ГЭМТ ХЭРЭГ" СЭДЭВТ ӨРГЭЛЖИЛСЭН БАГЦ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ДУУСЛАА



Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дээрх гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд анхаарах асуудал, гадаад орны туршлага, үндэсний болон олон улсын эрх зүйн зохицуулалт, гэмт хэргийг нотлох ажиллагаа сэдвийн хүрээнд прокурорууды чадавхжуулах зорилгоор үргэлжилсэн багц сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр 3 дугаар улирлын турш явуулж, сүүлийн хичээлийг 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгууллаа.

Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр "Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практик", Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүн, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Б.Энхболд "Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тухай ойлголт, онолын үндэс, үндэсний болон олон улсын эрх зүйн зохицуулалт", Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүн, хууль зүйн ухааны доктор Я.Цэлмэн "Эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа", Хүний Эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг "Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг шалган шийдвэрлэж

буй гадаад орны туршлага /мендезийн зарчим/, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Р.Батнасан “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн нотлох ажиллагаа ба прокурорын хяналт”, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн хяналтын прокурор Б.Уганбаатар “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг шийдвэрлэхэд анхаарах асуудал” гэсэн нийт 6 сэдвээр үргэлжилсэн сургалтыг явуулсан бөгөөд Улс, аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газрын прокуроруудбүгд хамрагдсан байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1946